



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 5/2

Хэрлэн сум

Ажил хавсран гүйцэтгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.2, Соёлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 26 дугаар зүйлийн 26.1, 50 дугаар зүйлийн 50.1, 50.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын даргыг томилогдох хүртэл хугацаанд бүжиг ангийн багш Д.Цогт-Эрдэнийг 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн даргын ажлыг хавсран гүйцэтгэгчээр томилсугай.

2. Д.Цогт-Эрдэнэд үндсэн цалингийн 40 хувиар нэмэгдэл олгохыг нягтлан бодогч /С.Болортуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Ажил хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|-----------------|---------------|--|
| Комиссын дарга: | Г.Лхагвахатан | Нийгмийн бодлогын хэлтсийн дарга |
| Гишүүд: | Ц.Мөнгөнзул | Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн |
| | Ц.Сүнжидмаа | Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын нярав |

4. Ажлыг хүлээлцүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА